

ХII зууны Монголд “тайш” гэдэг албан тушаалтан байв уу?

Гэрэлбадрах Ж.
/МУБИС/

Монголын түүх судлалд төдийлөн сайтар судлагдаагүй түүхэн үе бол Хабул ханаас Есүхэй баатар хүртэлх үеийн Монголын түүх ажээ. Түүх судлаачид Чингис хааны үеийн Монголын түүхийг товойлгон авч, тал бүрээс нь тодорхой судалсан атлаа түүний өмнөх үеийг ихэнхидээ үйл явцыг тоочих, эсэхүл сурвалжийн мэдээг нягтлалгүйгээр шууд авч хэрэглэх байдлаар өгүүлсээр иржээ.

ХII зууны Монголын түүхийн зарим нэг зүйлийг урьд өмнө бичиж, тодорхойлж байснаас өөрөөр нотлон тайлбарлаж болохуйц байна. Энд тухайлан “*tayisi*”–тайш хэмээх албан тушаалтан байв уу?, үгүй юу? гэдэгт хариулахыг оролдсу.

ХII зууны Монгол улсад улсын цэргийн хэрэг эрхэлсэн “*tayisi*”–тайш цолтой албан тушаалтан байсан, эсэх нь маргаантай юм. “Монгол улсын түүх”–энд “Амбагай хаан улсын төрийн зохион байгуулалтанд өөрчлөлт оруулж “тайш” гэдэг хааны дараах эрх мэдэлтнийг бий болгожээ. Улсын тайш тушаалд түүний дунд хүү Хадаан байжээ. Улсын тайш бол тэр цагтаа улсын цэргийн хэргийг голлон мэдэгч байсан байна”¹ хэмээн өгүүлсэн байдаг. Мөн Д.Гонгор, Ч.Далай нарын цөөнгүй эрдэмтэд эл үзэл баримтлалыг дагажээ.²

Лувсанданзан гүүшийн удирдлагаар туурвисан “Алтан товч”–ид “*amayar qayan qadayan qutala qoyar-i nereyiddügsen-ber qamuy mongyol tayiciyut onan-u qorquy jigür-tür qutala-yi qayan bolyaba. qadayan-i tayisi bolyaba*”³ (Амагар хаан Хадаан Хутала хоёрыг нэрийдснээр Хамаг Монгол, Тайчиуд Ононы Хорхуг жигүрт Хоталыг хаан болгов. Хадааныг тайш болгов) хэмээн өгүүлсэн байдгийг олонхи судлаач гол үндэслэлээ болгож байна. Тэд “Монголын нууц товчоон”–д Хадааныг “*tayisi*”–тайш болгосон талаар дурдаагүй орхисныг “Алтан товч”–ид тодруулан нөхөж бичсэн хэмээн үзжээ.

¹ БНМАУ-ын түүх. I. УБ., 1966. т. 175. Монгол улсын түүх. УБ., 2003. т. 59

² Гонгор Д. Халх товчоон. I. УБ., 1970. т. 74-75. Далай Ч. Монголын түүх. Хамаг Монгол улс (1101-1206). УБ., 1996. т. 48-49

³ Лувсанданзан. Эртний хадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой. УБ., 1990. т. 11a-11b

Энд тухайлан “qadaγan-i tayisi bolγaba” (Хадааныг тайш болгов) гэсэн өгүүлэмж түүхэн үнэнд аль хэр нийцэх вэ? гэсэн асуулт гарч байна. Энэ нь Лувсанданзан гүүшийн хийсэн оруулга байж болох уу?

П.Пеллио–гийн үзснээр монголчуудын дунд хятадын тай-цзы–тайiji 太子, тай-ши–тайisi 太师 хэмээх хоёр цолыг холин хэрэглэх явдал Кидань улсын (X–XII зуун) үеэс эхэлжээ⁴. Кидань хэлэнд t'ai-tsi–тай-цзы 太子 нь tayisi–тайш 太师 болон хувирсан байв. Түүнийг даган монголчууд хан хөвүүнийг tayisi–тайш 太师 гэж өөр утгатай үгээр нэрлэж байжээ. Хожмоо хятадуудтай харилцахын хэрээр хан хөвгүүнийг их багш буюу тайш гэсэн өөр хятад үгээр нэрийдэж байгаагаа мэдээд тайiji–тайж 太子 хэмээн зөвөөр нэрлэх болсон байна. Өөрөөр хэлбэл, “Монголын нууц товчоон”–д хан хөвүүн буюу тайiji–тайж 太子 хэмээн бичих гээд их багш буюу tayisi–тайш 太师 гэж бичснийг хожмын түүхчид анзааралгүй явсаар иржээ. Хаан ширээ залгамжлагч, хан хөвүүнийг тухайн үгийн утгаас нь өөрөөр tayisi–тайш 太师 хэмээн тэмдэглэжээ.

Рашид ад-дин “Судрын чуулган”–д Хадаан, Нэгүн нарыг тайш⁵ хэмээн бичсэн нь мөн уг уламжлалт алдааг даган бичсэн хэрэг болой.

Тэгвэл яагаад “Алтан товч”–ид tayisi–тайш хэмээх албан тушаалтны талаар тодорхой өгүүлдэг вэ? Юуны өмнө “Алтан товч”–ийг “Монголын нууц товчоон”–оос даруй 400 орчим жилийн хойно бичигдснийг ямар нэг хэмжээгээр харгалзан үзэх ёстой. “Алтан товч” нь “Монголын нууц товчоон”–ы дийлэнхи хэсгийг бараг тэр чигээр нь тусгасан, түүний өөр нэг хувилбар эхийг ашигласан чухал сурвалжийн нэг мөн хэдий ч цаг хугацааны хүчин зүйл, редакторын оруулга нөлөөлсөн зэргийг бодолцох хэрэгтэй.

Монголчуудын “тайiji”–ийг “тайisi” хэмээн андууран бичиглэдэг ёсыг XVII зууны сударч Лувсанданзан гүүш дагаж, тэр ч байтугай “qadaγan-i tayisi bolγaba” (Хадааныг тайш болгов) хэмээн tayisi–тайш цолтон байсан мэтээр зохион бичсэн байна. Лувсанданзан гүүшийн энэ алдаатай нэмэлт оруулга XII зууны Монгол улсад угаас tayisi–тайш цол бүхий албан тушаалтан байжээ гэсэн зохиомол ойлголтыг Монголын түүхийн утга зохиолд бий болгожээ.

Тайш–тайisi 太师 гэдэг нь хааны багш, их сургагч гэсэн утгатай эртний хятадын түшмэлийн цол⁶ бөгөөд энэ нь монголчуудын дунд Юань улсын үеэс эхлэн өргөн хэрэглэгдэх болсон ажээ.⁷ Учир иймийн тул 1–т, цаг хугацааны хувьд XII зуунд Хадааныг “taiysi”–“тайш” байсан гэх нь эргэлзээтэй, 2–т, Хадаан эцэг Амбагай хааны их багш буюу “taiysi”–“тайш” байж болохгүй нь ойлгомжтой юм.

Хурхын голын Хорхунаг жубурт болсон ноёд язгууртны хуралдаанаар Нирун-хияд овгийн Хотула, Тайчиуд овгийн Хадаан хоёрыг хэлэлцээд Хотулыг хаан өргөмжилжээ. Тэр тухай “Монголын нууц товчоон”–д “ambaqai-qahan-nu qada'an qutula qoyar-i nereyitcū ilēkse'er qamuq mongqo[I] tayiči'ut onan-nu qorqonaq-jubur quraju qutula-

⁴ Paul Pelliot. Notes sur le “Turkestan” de M.Barthold. T'oung Pao.Leide.1930.vol.XXVII.p.44-48

⁵ Рашид ад-дин.Сборник летописей.т I. кн II. М-Л.,1952.стр.23,37-40,42-45,47

⁶ Рашид ад-дин.Сборник летописей.т I. кн II. М-Л.,1952.стр.271

⁷ Гэрэлбадрах Ж. XV-XVII зууны Монголын ноёд язгууртны зэрэг дэвийн асуудалд. УБ., 1999.т.17-19

yi qahan bolqaba”⁸ (Амбагай хааны Хадаан, Хутула хоёрыг нэрийдэж илгээснээр Хамаг Монгол, Тайчиуд нар Ононы Хорхонаг жубур хураж Хутулыг хаан болгов) хэмээн өгүүлдэг.

Энэ хэрэг явдлыг судлаач Цойж, Хадааныг эцэг Амбагай хааны үед тайш болсон, Хотулыг хаан болох үед Хадааныг дахин тайш болгосон хэмээн үзсэн нь тийм биш бололтой. Хаан сонгосон хуралдаанд түүний удаахь хүнийг онцлон бичсэн нь юуны өмнө хаан болохоор өрсөлдсөн хоёр хүнийг адил тэнцүү өгүүлснээс үүдэлтэй юм. Мөн Монгол улсад тэргүүлэх нөлөөтэй хоёр гол аймгийн эрх мэдлийг тэнцвэржүүлж, дотоодын эв нэгдэл, тогтвортой байдлыг хадгалах зорилготой байсныг илэрхийлсэн гэж тайлбарлаж ч бас болно.

Үүнээс өөрөөр улсын цэргийн хэргийг эрхэлсэн *tayisi*–тайш 太師 хэмээх албан тушаалтан байсан, түүнийг нь дахин баталсан хэрэг огт биш юм. Чингэж үзэх барим тавим нотолгоотой зүйл алга байна.

Хадаан бол Монгол улсын бүх цэргийн жанжин байгаагүй, харин Амбагай хааны орыг залгаж хаан болох боломжтой хан хөвүүн–*tauyiji* байсан юм. Амбагай хааны арван хөвүүдийг бүгдийг бус, зөвхөн Хадааныг бусдаас онцгойлон *tayisi*–тайш хэмээн нэрийдэж байсан нь ямар учиртай вэ? Энэ нь Хадааныг эцгийн орыг залгаж хаан ширээ залгамжлагч байх бүрэн боломжтой ухаан төгс, дайчин баатар эр байсныг л илтгэж байгаа мэдээ юм.

Хотула хаан болоод Хадаан тайжтай хамтран Татараас өшөө авахаар довтолсныг “Нууц товчоон”–д “*qutula qahan bolu’at qada’an-taisi qoyar tatar irgen-tür morilaba*”¹⁰ (Хутула хаан болуут Хадаан тайш хоёр Татар иргэнд морилов) хэмээн өгүүлдэг. Мөн “Судрын чуулган”–ы мэдээгээр бол монголчууд Хотулыг хаан өргөмжлөөд бүх цэргээ түүнд захируулан Амбагай хааны өшөөг авахаар Алтан улс руу довтолж, амжилтай дайтаж байсан¹¹ нь хаан улсынхаа бүх цэргийг мэдэн захирч байсныг харуулж байна. Дээрх хоёр сурвалжийн мэдээгээр Хадаан бус, харин Хотула хаан улсынхаа бүх цэргийг бүрэн мэдэж захирч байсан байна.

“Монголын нууц товчоон”–ы хятад ханзыг галигласан эрдэмтэд уг үгийг “тайж” 太子, “тайш” 太師 –ийн аль алинаар галигласан байна.

Л.Лигети “*taisi*”¹², И.д.Рахевилц “*tayisi*”¹³ хэмээн тус тус галиглажээ. Э.Хэниш “*tai-tzë*” хэмээн галиглаад “*ältester prinz*”–хааны том хүү, “*kronprin*”–хаан ширээ залгах хөвүүн¹⁴ гэж тайлбарласан байна. “Нууц товчоо” судлаач Солонгосын эрдэмтэн Юү Вонсү үүнийг “*tauyiji*”¹⁵ хэмээн галигласан байна.

⁸ Index to The Secret History of the Mongols, by Igor de Rachewiltz. Bloomington. 1972. p.24

⁹ Алтан товч. Цойж тулган харгуулж тайлбарлав. Хөх хот. 1999. т.72-73

¹⁰ Index to The Secret History of the Mongols, by Igor de Rachewiltz. Bloomington. 1972. p.24

¹¹ Рашид ад-дин. Сборник летописей. т. I. кн II. М.-Л., 1952. стр.43

¹² Histoire secrete des Mongols. par Louis Ligeti. Budapest. 1971. p 34

¹³ Index to The Secret History of the Mongols, by Igor de Rachewiltz. Bloomington. 1972. p. 22,24

¹⁴ Worterbuch zu manghol un niuca tobca’an (Yuan-ch’ao pi-shi). Geheime geschichte der mongolen. von Erich Haenisch. Wiesbaden. 1962. p.144

¹⁵ Mongol bisa (The Secret History of the Mongols) by Yu Wonsoo. Seoul. 2004. p.324, 326

“Монголын нууц товчоон”-д Монголын Амбагай хааны хөвүүн Хадааныг 2 удаа, Бардан баатрын хөвүүн Нэгүнийг 6 удаа, Хэрэйдийн Алин (Арин-Ж.Г.)-ыг 1 удаа *tayisi*–“тайш” хэмээн өгүүлсэн нь энэ гурван хүнийг хааны хөвүүн, хааны удмын хүн хэмээн нэрлэх гэсэн нь илт байна. Тайж–*tauji* 太子 нь хан хөвүүн гэсэн утгатай хятад үг ажээ.¹⁶

Үүнээс арай хожим Их Монгол улсын үед Монгол газар аялж явсан Хятадын элчин төлөөлөгчид Чингис хааны хөвүүдийг нэг бүрчлэн дурдахдаа хан хөвүүн буюу тайж–тай цзы 太子¹⁷ хэмээн тэмдэглэжээ. Монголчууд богино хугацааны дотор “*tayiji*”–тайж 太子, “*tayisi*”–тайш 太师 хоёр цолыг хольж хэрэглэж байсан алдаагаа засаж чадсныг үүнээс мэдэж болно.

П.Пеллио “Монголын нууц товчоон”-д дурдагдах “*tayisi*”–тайшийг өв залгамжлагч, угсаа залгамжлах хан хөвүүн гэдэг утгатай “тай–цзы” 太师 хэмээх хятад үг бөгөөд монголоор “*tayiji*”–тайж хэмээн бичдэгийг шууд заан өгүүлсэн байна.¹⁸

Бямбын “Асрагч нэртийн түүх”–энд “*you-a muquli-da syi ong činsang tayisi čola ögčü tuу bariyulju tümen-i medeged yisün gem-dür eregüü-dür buu orutuуai gebe*”¹⁹ (Гоо Мухулид гүй он чинсан тайш цол өгч туг бариулж түмнийг мэдээд есөн гэмд эрүүд бүү ортугай гэв) хэмээсэн буй. Энд дурдагдаж буй “*tayisi*”–тайш цол бол хожмын түүхч сударчийн нэмэж бичсэн мэдээний нэг юм.

Тэгвэл Лувсанданзан гүүшээс хойш улсын цэргийг захирдаг “*tayisi*”–тайш 太师 цолтныг бид хэрхэн бий болгов? Амбагай хаан нас барсны дараа хаан ширээг хэн залгах талаар багагүй маргаан зөрчил гарчээ. Амбагай хааны нэр заасан Хотула, Хадаан хоёрыг ихэс язгууртны хуралдайгаар хэлэлцээд Хотулыг хаан болгожээ.²⁰

Амбагай хааны дунд хөвүүн Хадаан тайж хаан болж чадаагүй ч Тайчиуд аймгаа толгойлсон, үлэмж хүч нөлөөтэй хүн хэвээр байсан. Тэрбээр Монгол улсын төвийн хэсгийг захирч, Хотула хаантай хамтран Татаргаас эцгийнхээ өшөөг авахаар байлдаж байв.²¹ Хадаан тайж заримдаа Хотула хаанаас илүү эрх мэдэлтэй байсан мэт харагдах хийгээд Мэргид аймагтай байлдах асуудлыг хэлэлцүүлэхээр ноёдын хуралдайг зарлан удирдан хуралдуулж байсан ажээ.²² Улмаар Монголын цэргийг удирдан Мэргидтэй хэдэнтээ дайтаж, ялалт байгуулжээ.

Хадаан тайжийн энэ бүх бусдаас ялгаран товойсон цэрэг–байлдааны идэвхитэй үйл ажиллагааг дөвийлгөн тайлбарлаж, түүнийг цэргийн хэрэг эрхэлсэн хааны дараах “*tayisi*”–тайш 太师 гэдэг албан тушаалтан байсан гэсэн зохиомол зүйлийг түүх судлалд бий болгожээ.

¹⁶ Владимирцов Б.Я. Общественный строй монголов. Монгольский кочевой феодализм. Л., 1934. стр.142

¹⁷ Мэн-да бэй-лу. полное описание монголо-татар. факсимиле ксилографа перевода с китайского, введение, комментарий и приложения Н.Ц.Мункуева.М.,1975. стр.254

¹⁸ Paul Pelliot. Notes sur le “Turkestan” de M.Barthold. T’oung Pao.Leide.1930.vol.XXVII.p.44-48

¹⁹ Byamba-yin Asarayči neregъ (-yin) teške. галиглаж, үгийн хэлхээг үйлдэн хэвлэлд бэлтгэсэн Цэвэлийн Шагдарсүрэн, И Сөн гю.УБ.,2002. т.250

²⁰ Гэрэлбадрах Ж.Амбагай Хотулыг хаан болгохоор захисан уу ?. Acta Mongolica.t.V.УБ.,2004.т.187-190

²¹ Index to The Secret History of the Mongols. by Igor de Rachewiltz. Bloomington.1972.p. 22.24

²² Рашид ад-дин.Сборник летописей.т I. кн II. М-Л.,1952. стр. 38

Үүний эх үндэс нь Лувсанданзан гүүшийн нэмэлт оруулга болдог. Энэ бол Лувсанданзан гүүш нар “Алтан товч”-оо зохиохдоо “Монголын нууц товчоон”-д байхгүй цөөнгүй зүйлийг нэмэж бичсний нэг ажээ. Тайчиудын Сорхон шарын охин Хадааны эр нөхөр Чингисийн цэрэгт алагдсан²³ атал “Лу.Алтан товч”-ид түүнийг аварсан хэмээн²⁴ өөрчлөн нэмэж бичсэн гэх зэргээр редакторын хүчин зүйл орсон иймэрхүү жишээ олныг өгүүлж болно.

Мөн Монголын түүх судлалд “Есүхэй баатар бол үнэн хэрэг дээрээ 1170 оноос нэлээд өмнө үед Хамаг Монголын өргөмжлөгдөөгүй хан болсон бөгөөд улсын тайш нь түүний ах Нэкүн байжээ”²⁵ хэмээн “*tayisi*”-тайш цолтон дараа дараагийн үед ч байсан хэмээн үздэг.

“Монголын нууц товчоон”-д 1189–1190 оны үед болсон нэгэн найран дээр Жүрхиний Сача бэхийн хатад тогооч Шихүрийг занчихад тэрбээр “*yisügei-ba’adur nekün-taisi qoyar-i üküü-yin tula eyin ašgikdaqui minu ya’un ke’e’et yeke dawu-bar uyilaju’ui*”²⁶ (Есүхэй баатар Нэгүн тайш хоёрыг үхэхийн тул ийн ашигдахуй минь юун гээд их дуугаар уйлжээ) хэмээн өгүүлдэг. Энэ нь Есүхэй баатрын Монгол аймгуудыг нэгтгэн захирах хэрэгт түүний ах Нэгүн багагүй үүрэгтэй оролцож байсныг гэрчлэх мэдээ болохоос Нэгүнийг улсын цэргийг захирах “*tayisi*”-тайш 太師 цолтон байсныг яг таг нотолж чадахгүй байна.

Хэрэв үнэхээр “*tayisi*”-тайш 太師 цолтон байсан, тэр нь улсын цэргийг захирдаг байсан бол 1189 онд Монголын хаанаар өргөмжлөгдсөн Тэмүжин яагаад эцэг өвгөдийн үеэс уламжлан ирсэн “*tayisi*”-тайш цолыг огт авч хэрэглэсэнгүй бэ? Мөн 1206 онд Чингис хаан нэгдсэн Монгол улсыг байгуулж, цэргийн албан тушаалтнуудыг тохоон томилохдоо Хубилай ноёныг “*ci qubilai cerig-ün üyile bügüde-yi aqalaju ülü’ü aqu ke’en soyurqaju jarliq bolba*”²⁷ (Чи Хубилай цэргийн үйл бүгдийг ахлаж үлүгү аху хэмээн соёрхож зарлиг болов) хэмээн цэргийн бүх хэргийг түүнд хариуцуулсан байна. Чингэхдээ Хубилайд ямар нэгэн цол хэргэм өгөөгүй ажээ. Чингис хааны “*tayisi*”-тайш цолтныг томилоогүйн гол учир нь анхнаасаа л тийм цол, мөн тийм цолтой албан тушаалтан байгаагүйд л оршиж байна.

Мөн “*tayisi*”-тайш 太師-ийг улсын нэг гар, хэсгийг захирдаг хүний цол байсан гэж үзэж болох авч энэ нь төдий л үнэмшилтэй болж чадахгүй байна. Хадаан эцгийгээ амьд байхад Монголын төвийн хэсгийг захирч байсан нь Хотула хааны үед ч үргэлжилсэн билээ. Хотула нэгэнт хаан болсон тул Тайчиуд нараас уг эрх мэдлийг авч төвдөөгүй, ингэх ч шаардлагагүй байв.

Хотула Монгол улсын баруун хэсгийг захирч байхад зүүн хэсгийг мэдэж байсан Ариг чоно ямар нэгэн цол гуншингүй байв.²⁸ Хэрэв улсын нэг гар, хэсгийг захирагчид

²³ Index to The Secret History of the Mongols. by Igor de Rachewiltz. Bloomington. 1972. p.65

²⁴ Лувсанданзан. Эртний хадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой. УБ., 1990. т.43б-44а

²⁵ БНМАУ-ын түүх. I. УБ., 1966. т.176

²⁶ Index to The Secret History of the Mongols. by Igor de Rachewiltz. Bloomington. 1972. p.55

²⁷ Index to The Secret History of the Mongols. by Igor de Rachewiltz. Bloomington. 1972. p.120

²⁸ Рашид ад-дин. Сборник летописей. т. I. кн II. М.-Л., 1952. стр.39

тайш цол өгдөг байсан бол Ариг чоныг мөн “tayisi”–тайш хэмээн нэрийдэх байв. Гэтэл тэгээгүй байна.

Энэ бүхний эцэст XII зууны Монгол улсад цэргийн хэргийг дагнан эрхэлсэн “tayisi”–тайш 太师 цолтон байгаагүй гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Хааны хөвүүнийг “tayiji”–тайж 太子 хэмээн нэрлэх гээд “tayisi”–тайш 太师 хэмээн андууран бичиглэж байсан нь тийнхүү үзэхийн үндэс болжээ.

ABSTRACT

Does a title “tayisi” in 10th – 12th centuries Mongolia?

It has been widely misunderstood that the title for the prince, or the next man to the khan (king) was “tayisi” 太师 in the 10th–12th centuries Mongolia. This misunderstanding was caused by the Mongolian historiographies which confused the title “tayiji” (prince) 太子 with the “tayisi” (teacher of the khan, great instructor) as we see in *The Secret History of the Mongols*, which chose not the correct “tayiji” 太子 but the wrong “tayisi” for the ‘prince’. Then a phrase, *Qadaγan-i tayisi bolγaba* in Blo-bzan bstañ –’jin *Altan Tobci*, which is a 17th century Mongolian chronicle, spread the above mentioned misunderstanding.

On the basis of the historical facts, this paper concludes that the title for the “prince, son of a khan” was not the “tayisi” 太师 but the “tayiji” 太子 in that period, and the title “tayisi” 太师 has been widely used from the 14th century in the meaning of “teacher of the khan, great instructor.”